



ДУНДГОВЬ АЙМАГ  
БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 07 өдөр

Дугаар 8/33

Аргатай

Хагас жилийн малын түүвэр судалгааны  
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 20 дугаар зүйлийн 20.2, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/324 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. 2023 оны хагас жилийн малын түүвэр судалгааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Б.Золзаяа (Засаг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга: Д.Мөнхзул (Төрийн сангийн мэргэжилтэн)

Гишүүд: М.Мөнгөнхуяг (1 дүгээр багийн засаг дарга)

Э.Дашдамба (2 дугаар багийн засаг дарга)

П.Амарсанаа (Жолооч)

Хоёр. Хагас жилийн малын түүвэр судалгааг 2023 оны 05 дугаар сарын 30-наас 06 дугаар сарын 06-ний хооронд зохион байгуулахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд даалгасугай.

Гурав. Түүвэр судалгааны мэдээ тайланг заасан хугацаанд чанартай хийж гүйцэтгэхийг нарийн бичгийн дарга (Д.Мөнхзул)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Б.ЗОЛЗАЯА